

ДеФакто **ТОЙМ**

➤ ГАДААДАД БАЙГАА
МОНГОЛЧУУД

➤ ЭРХ ЧӨЛӨӨ БА
МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

➤ ТӨР БА НАМД ИТГЭХ
ИТГЭЛ АЛДАРСАН НЬ

IX НҮҮРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

Төрийн “МОТОРТОЙ” Бизнес

II НҮҮРТ



БОЛОВСРОЛ

Б.Насанбаяр
Ph.D /Боловсрол судлал/

СУМ СУРГУУЛЬГҮЙ БОЛ

IV НҮҮРТ



ХУУЛИЙН ЗАСАГЛАЛ

Ц.Батболд
Хөгжлийн эдийн засагч (PhD) бөгөөд
АНУ-д мэргэжлээрээ ажиллаж байна

АРДЧИЛАЛ БА ҮНДСЭН ХУУЛЬ

VI НҮҮРТ

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.02.14, №84

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn





Дамбадаржаагийн ЖАРГАЛСАЙХАН

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

Төрийн “МОТОРТОЙ” Бизнес

Улс үндэстний хөгжил цэцэглэлт, энх амгалан амьдрал нь улс төрийн ардчиллын чанар, чөлөөт зах зээлийн эдийн засгийн суурь болон шинийг санаачлах чадвараас хамаардаг. Эдгээрийн дотроос чөлөөт зах зээлийн эдийн засаг нь аль хэр бат бэх суурьтай байгаа эсэх нь иргэдийн амьдралын түвшинд хамгийн их нөлөөлдөг. Чөлөөт зах зээл нь эдүгээ ихээхэн шүүмжлэл дагуулах боллоо.

Чөлөөт зах зээлийн буюу капиталист эдийн засгийг нийгмийн тэгш бус байдлыг өөгшүүлдэг, хүн төрөлхтнийг хэрэглээний нийгэм рүү түлхэж, улмаар цаг уурын өөрчлөлтийг бий болгосон гэх зэргээр сүүлийн үед ихэд шүүмжлэх боллоо. Чөлөөт зах зээл нь эдийн засгийн харилцааг зөв зохицуулж чадахгүй гэх үзэл ч хүчтэй гарч байна.

Өнөөдөр капитализмыг хоёр хэсэгт хувааж болно. Нэг нь шударга өрсөлдөөн бүхий чөлөөт зах зээлийн, нөгөө нь шударга бус өрсөлдөөн буюу

төрийн “мотортой” эдийн засаг. Сүүлийнхийг нь крони (crony) капитализм гэж нэрлэдэг. Чухам энэ крони капитализм эдүгээ ихэнх хөгжиж буй орнуудад эрчимтэй тэлж, улмаар чөлөөт зах зээлийн эдийн засгийн нэр хүндийг бүхэлд нь унагаж байна. Крони капитализмаас болоод хүмүүс капитализмыг дэмжихээ больж байна гэж Wall Street Journal (2015) бичжээ.

Крони капитализм (танил талын бизнес) гэдэг нь тухайн орны төр засгийн шийдвэр нь найз нөхөд, танил тал, холбоотныхоо компанид хөнгөлөлттэй зээл, тусгай зөвшөөрөл олгох, бусад компани оролцох боломжийг хязгаарлах зэргээр тухайн салбарт яваандаа монополь тогтоох боломж олгохыг хэлж байна. Энэ бүхнийг тохируулан гаргасан шийдвэр, хууль, журмын хүрээнд хийгддэг учир авлига гэж үздэггүй. Харин хуульчлагдсан хулгай гэж хэлдэг.


КРОНИ КАПИТАЛИЗМЫН ИНДЕКС

Ер нь крони капитализм гэдэг нэр томьёо нь 1997-98 оны Азийн эдийн засгийн хямралын үед гарчээ. Энэ хямралын суурь шалтгаан нь крони капитализм гэж Калифорнын Их сургуулийн судлаач Андрью Маккинтайр Индонез, Тайландын жишээн дээр тайлбарлажээ. Зүүн өмнөд Азийн олон орныг хамарсан энэ хямрал “халуун мөнгө” буюу хүүгийн зөрөөн дээр богино хугацаанд ашиг хийх зорилготой их хэмжээний мөнгө гаднаас оруулснаар тухайн оронд хөрөнгийн үнийг хэт хөөрөгдөж эдийн засгийн хөөсрөлтийг үүсгэж, төдөлгүй эдийн засгийн хямрал дагуулав. Энэ их мөнгөний шилжилт, хөрөнгө оруулалтыг эдгээр орны төр засгийн удирдлага, тэдний хамаатан садан, найз нөхдийн (cronies) оролцоотой хийсэн ажээ.

The crony-capitalism index

Billionaire wealth as a % of GDP, ranked by crony-sector wealth

2014 2016



Sources: Forbes; IMF; The Economist

*Includes territories

► The Economist сэтгүүл саяхнаас (2014, 2016 онуудад) “Крони капитализмын индекс” гаргажээ. Эхлээд монополь үүсэх өндөр магадлалтай, тусгай зөвшөөрөл (лиценз) шаарддаг, төрөөс маш их хамааралтай: казино, нүүрс ба мод бэлдэх, батлан хамгаалах, хадгаламж татдаг банк, дэд бүтэц, онгоцны буудал, үл хөдлөх үндсэн хөрөнгө ба барилга, ган ба бусад металл боловсруулах, ашигт малтмал олборлох, ус түгээх, харилцаа холбооны үйлчилгээ зэрэг арван салбарыг сонгожээ. Тэгээд Forbes

сэтгүүлийн мэдээллээс тухайн салбарт байгаа тэрбумтнуудын хөрөнгийг улсынх нь ДНБ-тэй харьцуулан энэ индексийг гаргажээ. Харьцаа их байх тусам крони капитализмаас болж эдийн засаг нь хохирдог ажээ.

2016 оны индексийг гаргахдаа 23 орныг хамруулжээ. 2014 онд энэ индексийг Хонгконг, 2016 онд Орос тэргүүлжээ. Хойд хөршид дээрх арван салбарын тэрбумтнуудын нийт хөрөнгө Оросын ДНБ-ий 18 хувьтай, крони бус салбарт 1.8 хувьтай тэнцэж байна.

МОНГОЛЫН ЦЭЦЭГЛЭН ХӨГЖИЖ БУЙ КРОНИ БИЗНЕС

Манай улсын тухайд энэ индексийг гаргах боломж улам бүр бүрдсээр байна. Монгол улсад дээрх арван салбараас нүүрс, арилжааны банк, дэд бүтэц, үл хөдлөх үндсэн хөрөнгө ба барилга, ашигт малтмал хайж олборлох, харилцаа холбооны салбарууд хамааралтай. Тэгвэл төр засгийн шийдвэр гаргагчид, өмнөх удирдлагууд оролцоогүй ямар нэг салбар энд байна уу? Манайд өөрийн бизнесийн салбартай холбоотой хууль баталдаг гишүүд, төсвийн мөнгөөр өөрийн бизнест давуу боломж олгодог сайд, өөрийн банктай гишүүд бол олон байна.

Монополь үүсэх магадлал бага салбаруудад ч манай улсад крони капитализм хөгжиж байна. Өөрийн ББСБ-гүй, эсвэл хувийн их дээд сургууль байгуулаагүй, хувьчлалаар аль нэг объект аваагүй, эсвэл ямар нэг орд газрын лицензгүй, газар аваагүй, хувийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлгүй төрийн түшээдийг Монгол улсад олоход хэцүү болжээ. Тэд бүгд л өөрийн бизнест ашигтай хууль журам гаргуулж, хөнгөлөлттэй зээл, тусламж авч бизнесийн давуу боломжийг өөрсдөдөө, хамсаатнууддаа олгож ирлээ.

Монголын төр олон төрлийн сан байгуулж, төрийн банктай болж, гадаадад бондоор зээл авч, өөрсдийн компаниудаа санхүүжүүлэв. Богд уулын бүх ам, нийслэлийн бүх парк, үнэ цэнэтэй газрыг хуйвалдан борлуулав. Үнэ тогтворжуулах хөтөлбөр, орон сууцны хөнгөлөлттэй зээл нэрээр

нийтийн хөрөнгөөр өөрсдийн банк, барилгын компаниудыг санхүүжүүлэв. Үнэ хөөрөгдөж, иргэдийн худалдан авах чадвар навс унав. Төлж чадахгүй их зээл валютаар авсан учир төлбөрт нь төгрөг сулрав.

ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн олон тэрбум төгрөгийг УИХ-ын 15 гишүүн хувааж аваад ББСБ-аараа дамжуулаад угаасан нь саяхан илэрсэн ч, өмнөх авлигын олон хэргийн адил чимээгүйхэн мартуулах зам руугаа шилжиж байна.

Ийнхүү крони капитализм буюу төрийн “мотортой” бизнес ид цэцэглэж байгаа Монгол улсад авьяас чадвар, хувийн хөрөнгө, ур чадварт суурилсан бизнес улам явахгүй болж, ажлын байр хумигдаж, иргэд нь гадаад орныг зорих боллоо.

Крони капитализмтай зөвхөн хувийн бизнесийн холбоод, юуны өмнө хуулиар хариуцсан үүрэгтэй Худалдаа Үйлдвэрийн танхим идэвх санаачилгатай тэмцэж чөлөөт өрсөлдөөнийг бүрдүүлэх цаг болжээ. Оройтвол биднийг Венесуэлийн хувь заяа хүлээж байгаа.

Төр засагтай холилдож ойрхон зайг хурдан явах уу, эсвэл чөлөөт өрсөлдөөнөөр хол зайд баттай явах уу гэдгийг монголын компаниуд сонгох цаг ирлээ.

2019.02.13 ■



НИЙТЛЭЛ

Баавгайн НАСАНБАЯР

Ph.D /Боловсрол судлал/

СУМ СУРГУУЛЬГҮЙ БОЛ ...

Ерөнхий боловсрол эзэмших явцдаа хүн насан туршдаа ажиллаж амьдрах мэдлэг, хандлага, нийгмийн харилцаанд оролцох чадварт суралцдаг. Ерөнхий боловсролын чанар нь хүний хөдөлмөрийн бүтээмж, амьдралын түвшинд нөлөөлдөг. Энэхүү чанар нь санхүүжилтийн зарчим, хэмжээнээс

маш их хамааралтай. Манай улсын ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилтийн дийлэнхийг хувьсах зардал буюу суралцагчдын тоогоор улсын төсвөөс олгодог санхүүжилт эзэлдэг. Энэ санхүүжилтийн аргачлалыг эргэн харах шаардлага тулгараад байна.

БОЛОВСРОЛЫГ ДЭЭДЛЭХ ҮЗЭЛ

Ерээд оны картын бараатай, идэх өмсөхөөр ховордсон цагт хөдөөгийн иргэд “мал бол амьдралын баталгаа” гэж итгэж байлаа. Дунд сургууль завсардалт огцом нэмэгдэж 1997 онд ерөнхий боловсролын сургалтын хамралт 61 хувьд хүрч буурав. Харин энэ хувь таван жилийн дараа эргээд огцом өсч хөдөөд 90,2 хотод 89,9 хувь болж, 1990 оны өмнөх үеэс өндөр түвшинд хүрчээ. Хэдхэн жилийн дотор иргэдийн хандлага өөрчлөгдөж “боловсролболамьдралын баталгаа” гэх болов. Энэхүү баталгаа өгч буй боловсролын орчин тийм огцом сайжрахгүй байна. Сургалтын, тухайлбал материаллаг, үйлийн, сэтгэл зүйн орчин хүүхдийг хөгжүүлэхэд онцгой нөлөөтэй. Хүүхэд нас бол хүний амьдралын хамгийн хүчтэй “суралцах чадвартай” үе боловч бас хамгийн эмзэг үе. Тиймээс хүүхдийг тав тухтай, эрүүл аюулгүй орчинд байлгаж, тэднийг хайрлах, хүсэл сонирхол, сонголтыг хүндэтгэх нь хүн болж төлөвшихөд нь онцгой үүрэгтэй. Гэтэл хөдөөд ийм боломж хомсдолтой байгаа нь хүүхдийн сурч боловсрох эрхийг зөрчихөд хүрч байна. Энэ асуудлыг шийдэхийн тулд сумын сургуулийн санхүүжилтийн аргачлалаа өөрчлөх хэрэгтэй байна.

2018-2019 оны хичээлийн жилд Улаанбаатар хотын 245 сургуульд 263,412 хүүхэд сурч байгаа бол улсын хэмжээнд 388 баг, сумын сургуульд 171,180 хүүхэд сурч байна. Сумын сургуулиудын хүүхдийн тоо цөөрч байхад эсрэгээрээ зарим аймгийн төв, нийслэлийн сургуулиуд ачааллаа дийлэхгүй 28 сургуулийн 212 бүлэгт 8,451 хүүхэд гуравдугаар ээлжинд хичээллэж байна. Эдгээр гуравдугаар ээлжийн бүлгийн 85.4 хувь нь бага ангийн, 11.8 хувь нь дунд ангийн, 2.8 хувь нь ахлах ангийн бүлэг байна.

2015 онд сумын 387 сургуулиас 163 нь 300-аас доош, үүнээс 101 нь 200-аас доош хүүхэдтэй байв. Зарим сумын сургуульд тав, арван хүүхэдтэй ангиуд ч байна. Хэдэн хүүхэд сурахаас хамаарч сургуулийн тогтмол зардал, багшийн тоо зэргийг хүчээр танах боломжгүй. Гэвч хүүхдийн тооноос хамааралтай санхүүжилт нь нэг багш олон хичээл заах зэрэг чанаргүйдлийн тойрог үүсгэдэг. Чанаргүй сургуульд хүүхдээ сургахгүйн тулд эцэг эхчүүд сайн сургуультай төв суурин бараадсаар Монгол хот улс болоход ойрхон байна.

Төрөөс хөдөөг хөгжүүлэхээр бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг ч, сумын сургуулиас хөгжил нь хамааралтайг үл анзаардаг. Сургууль нь чанартай бол айл өрхүүд хөдөөнөөс суурин бараадаж нүүх нь багасна. Сумын сургуулийн тулгамдсан асуудлын шийдэл болгож 2016 онд Боловсролын тухай хуулийн 40.3-т "...сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан

өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно." гэсэн заалт батлагдсан. Гэвч энэ талаар ямар нэгэн ажил хийгдэхгүй байгааг харахад хариуцсан хүмүүс нь мэдэж байгаа эсэх нь эргэлзээтэй байна.

Сумын сургуулийн сургалтын чанар сайжирснаар гарсан үр дүнг 2016 онд Хэнтийн аймгийн Мөрөн сумын сургуулийн Ж.Мядагмаа багш эсэндээ ийнхүү өгүүлжээ.

"Аймгийн төвд ойрхон сумдын сургуулиудад үүсдэг төвийн сургуулиудад сурагчаа алдан, хүүхдийн тоо цөөрөх явдлын улмаас жилээс жилд элсэлт нь төгсөлтөө нөхөж чадахгүйд хүрсэн нь сургуулийн захирал төдийгүй багш бидний хувьд ч хөндүүр асуудал байлаа. Манай хамт олон сул талаа давуу тал болгох, хүүхэд нэг бүрийг бүхий л талаар хөгжүүлэх нь бидний хүндрэлээс гарах гарц хэмээн тодорхойлж, "Авьяс", "Ном" хөтөлбөрийг талархан хүлээж авсан билээ. Огт авьяасгүй хүн гэж үгүй учраас сурагчдын авьяасыг нээн хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхийн тулд сургуулийнхаа эрхэм зорилгыг "Хүүхэд бүрийн хөгжлийг хангасан хөтөч сургууль болно" хэмээн тодорхойлж, сурагч, эцэг эхчүүдээс авьяасын судалгаа авч, нэгтгэн дүгнээд үйл ажиллагааныхаа чиглэлийг тодорхойлсон. Багш бүр мэргэжил харгалзахгүйгээр өөрийн чадварт тулгуурлан сонгон дугуйлан хичээллүүлэхээр болж, төрөл бүрийн сургалтад хамрагдах, туршлага судлах зэргээр олон сувгаар эрэл хайлт хийсний үр дүнд 15 төрлийн сонгон дугуйлан хичээллүүлэх болсон нь сурагчдад авьяас чадвараа нээж, өөрийгөө олоход нь тусалсан. Сурагчдынхаа авьяас чадварын ахиц амжилтыг улирал бүр аймаг, орон нутаг, сургууль эцэг эхчүүддээ тайлагнан, ... эцэг эхчүүдийн сургууль, багш нарт хандах хандлага өөрчлөгдөн, хүүхдээ сонгон дугуйланд хамруулъя, хэрэгцээтэй зүйлээр тусалъя гэх эцэг эх олширсон нь хамтдаа нэг зүгт харж ажилласны үр шим. Авьяас хөтөлбөрийн ачаар манай хүүхдүүдийн "БИ чадна" гэсэн итгэл дүүрэн харц бидний зорилгодоо хүрэх замыг гэрэлтүүлж, урагш тэмүүлэх хүчийг өгдөг. Хүүхдүүд шилжээд байсан тухай бид одоо санахаа ч байж дээ."

ХӨГЖЛИЙН ГАРЦ

Сумын сургуулийн санхүүжилтийг нэмэгдүүлснээр хот, хөдөөгийн сургалтын чанарын ялгааг багасгах, хүүхэд бүрт ижил түвшний боловсрол олгох боломж тодорхой хэмжээгээр бүрдэнэ. Хүүхэд эцэг эх, гэр оронтойгоо ойр сургуульд суралцах нь эрүүл мэнд, зам тээврийн осол, хүчирхийлэл гэх мэт олон эрсдлээс тэднийг хамгаалж улс, орны эдийн засгийн хөгжилд өндөр үр ашигтай. Гэтэл сумын сургуулийг хөгжүүлэх бодлого, шийдэл тодорхойгүй байгаа нь эрх мэдлийг хэрэгжүүлэгчдийн хүүхдүүд ихэнх нь өндөр төлбөртэй хувийн сургуульд сурдаг учир тэднээс хол, бас үл ойшоодог байж болох юм. Хот, хөдөөд амьдарч байгаа хүүхдүүд сурч чадна, чадахгүй гэдэг ялгаа огт байхгүй. Хүүхэд бүр суралцах боломж бүрдвэл сайн суралцах чадамжтай.

Эхний ээлжинд 200 хүртэлх хүүхэдтэй 101 сургуулийн 10,087 гаруй сурагчдын хувьсах зардлыг Боловсролын тухай хуулийн 40.3. дахь

заалтыг үндэслэн 3 дахин нэмэгдүүлэхэд 13.6 тэрбум төгрөг төсөвт шаардлагатай болно. (2016 оны 242 дугаар Засгийн газрын тогтоолын дагуу сумын сургуулийн нэг сурагчид ногдох хувьсах зардал дунджаар 450,000 төгрөг)

Төрөөс хяналтгүй зарж буй олон сан (ЖДҮ), хөтөлбөрийн хүрээнд ноос ноолуур, үр тариа, шатахууны бизнесийг дэмждэг төсвөөс боловсролд зарцуулвал, урт хугацаандаа орлогын ялгаа багасч, хүмүүс хамтдаа ажиллаж, амьдрах ээлтэй нийгэм бүрдэнэ.

Нобелийн шагналт, эдийн засагч Жеймс Хейкман "боловсролд хөрөнгө оруулсан 1 доллар тутмын эргэх ашиг нь 13 доллар байна гэдгийг тооцоолж, хувь хүний хөгжилд оруулсан хөрөнгө оруулалт нь зөвхөн боловсрол олж авч буй тэр хэсэг хүмүүст бус, улс орны эдийн засгийн хөгжилд бүхэлд нь өндөр үр ашигтай байдаг" гэжээ.



НИЙТЛЭЛ

Ц.БАТБОЛД

Хөгжлийн эдийн засагч (PhD) бөгөөд
АНУ-д мэргэжлээрээ ажиллаж байна.

АРДЧИЛАЛ БА ҮНДСЭН ХУУЛЬ

Хууль бол ардчиллыг гажуудлаас хамгаалах баталгаа юм. Ардчилал санал зөрөлдөөнөө гудамжинд биш танхимд шийдвэрлэх ёстой болгодог бол, хууль олонхоор

түрэмгийлэн цөөнхийн буюу хувь хүний эрх ашгийг хохироохгүй болгодог. “Rule of Law” буюу хуулийн засаглал сул байвал популистууд яаж сүйрүүлдгийн жишээ нь фашизм.

ИТАЛИД



Италид 1922 онд хөдөлмөрчид, халагдсан байлдагчид дайны дараах хүнд байдлаас гаргаж чадахгүй Ерөнхий сайдаа огцруулахыг шаардан сонгуульд ялж, тэдний удирдагч Мусолини хамгийн залуу Ерөнхий сайд болсон байдаг. Үндсэрхэг үзлийнхээ улмаас Италийн социалист намын удирдлагаас хөөгдсөн, Швейцарт Ленинтэй уулзаж байсан гэдэг энэ сэтгүүлч цэргийн хуучин формтой 30 мянган ажилгүй дайчдын жагсаал зохион байгуулж,

бизнесменүүд, цэргийнхэн, ажилчид, оюутан залуучуудын шаардаж байсан бүхнийг амлаж, гол нь тэдний үндэсний үзэл дээр тоглосон гэдэг. Ромын цэргийн сүлд болох олсоор багласан фаши сүхээр намаа фашист гэж, өвгөдийн улсыг сэргээнэ гэж ард түмнээ хөөргөн, шударга ёс тогтоох нэрийдэлтэй большевикуудаас хуулбарласан дарангуйллыг нь ашгүй Италид галт тэрэг цагтаа хөдөлдөг болж байна гэж эхэндээ магтаж байсан гэдэг.

ГЕРМАНД



Дайн өдөөснийхөө шийтгэлд бүх колони, зарим нутгаа алдаж их торгууль хүлээсэн Германд “Үндэсний социалист герман ажилчдын нам” нэртэй гарч ирсэн “National Socialist” буюу нацист нам 1933 онд мөн бүх зовлонг арилгах сайхан амлалтаар Засгийн эрхэнд гарч, зураач болох гээд бүтээгүй, боловсрол ядмаг Гитлер эхлээд Канцлер, жилийн дараа Ерөнхийлөгч нэгтгэсэн “Führer” буюу их удирдагч болжээ. Тэрээр парламентын ордонг шатааж ял тохох замаар улс төрийн гол өрсөлдөгч коммунистууд болон өөрийг нь дэмжихгүй намынхаа нөхдийг намнаж, бусад намыг хориглон, хэвлэл мэдээллийг пропаганд болгов. Шүүмжлэх магадлалтай сэхээтнүүдийг мөшгиж эхэлснээр Германы соёл шинжлэх ухааны сор гадаадад их гарсны нэг Эйнштэйн, атомын бөмбөгийн мэдлэг өгч АНУ-д

герман гаралтан англи удамтайчуудаас ч олон болов. Германы дордолтод гадныхан ялангуяа Еврейчүүд буруутай, бид дээд заяатай “ариан” үндэстэн ялна гэж ард түмнээ хөөргөн, Ромыг дуурайсан дэлхийн нийслэл Германия төслөө “урлаач” өөрөө зохиосон байдаг. Еврейн онол гэж коммунизмыг үзэн ядагч түүнийг Зөвлөлтийн эсрэг түшиг гэж байтал 1939 оны 8-р сарын 23-нд Польш Балтид нууц тохироотой Молотов-Рыбентроп гэрээ байгуулагдаж, 9-р сарын 1-нд Гитлер Польшид довтолсон бол, 17-нд нь буюу Халх голын байлдаан дууссаны маргааш Зөвлөлтийн цэрэг зүүн талыг нь эзэлсэн байдаг. Ялтын гэрээгээр тэр бүх нутгийг ЗХУ-д үлдээж оронд нь Одер-Нил мөрөн хүртэлх Германы зүүн хэсгийг Польшид өгсөн байдаг.

АМЕРИКТ

ЗХУ-д тогтсон Сталины дэглэмийг ч фашизмтай адил “authoritarian” дарангуйлал гэж үздэг нь хуулийн засаглал (rule of law) биш, нам удирдагчийн эрх мэдлийн (rule of power) засаглал тогтож, хүний эрхийн түгээмэл зарчмууд зөрчигддөгт оршино. Эдийн засгийг төрийн мэдэлд авч цэргийн маягийн захиргаадалт төлөвлөлтөөр удирддаг нь тэдний бас нэг нийтлэг шинж байв. Үнэндээ ийм удирдлага өмчийн эрх, эдийн засгийн эрх чөлөө, чөлөөт өрсөлдөөнийг ихээхэн хязгаарлаж байж л хэрэгждэг. Сүүлийн үед ийм популист засаглал газар авч байгаа нь ялангуяа хуулийн дархлаа султай шилжилтийн болон хөгжиж байгаа орнуудыг хямруулж болзошгүйг Financial Times анхааруулжээ (М. Волф 1-р сарын 23). Түүний сонгодог жишээ Трамп гэнэ. Төрийн, олон улсын мэдлэг туршлагагүй, насаараа бохирдуу бизнес эрхлэж, дарангуйлагчид, мафийн арга барилд дуртай болсон тэрээр Ерөнхийлөгч болсон хойноо ч өөрийгөө дэмждэг боловсрол багатай хүмүүсийг хөөрөгдөж, хүмүүсийг үзэл бодол, өнгө угсаагаар нь хагалан талцуулж, буруу бүхнийг гадныханд чихэн, үндсэрхэг болон арьсны үзлийг өөхшүүлж байгаа нь нийгмийн дэвшлийг ухраагаад зогсохгүй, олон улсын хамтын ажиллагааг бусниулж байна. Хамгийн гол нь байнга худлаа ярьж, өөрийг нь шалгаж байгаа хуулийн байгууллагуудад нөлөөлж дайснаа даруулах, садан төрөл үнэнч багануудаа шургуулан хариуцлагаас мултрахын тулд хуулийн засаглалыг сулруулахыг оролдож байна. АНУ шиг хууль хэрэгждэг оронд ийм удирдагчийг зогсоож чадах бол, бусад орны

хувьд хуулийн засаглалаа сайжруулах замаар ардчиллаа хамгаалах шаардлагатай байна гэж өгүүлэл төгсжээ.

Ардчиллын хуулиудыг багцалсан анхны бичмэл үндсэн хууль АНУ-ынх бөгөөд түүний салшгүй хэсэг нь “Bill of Rights” гэж нэрлэгддэг хүний эрхийн нэмэлтүүд юм. Энэ нь Английн практикт тулгуурлан Монтеске “Хуулийн амин сүнс” бүтээлдээ боловсруулсан гурван засаглалын харилцан хяналт тэнцвэржүүлэлтийн зарчмыг хэрэгжүүлэх, гол нь Ерөнхийлөгчийг сонгох 538 хүнтэй “Electoral college” байгуулж популист Ерөнхийлөгч гарахаас сэргийлэх гэсэн загвар. Мөн татвар, төсвийн гол эрх мэдэлтэй 2 жилээр сонгогддог нийтийн танхимын шийдвэрийг Лордуудын вето маягаар хянан зөвших, 6 жилээр сонгогдон 2 жил тутам гуравны нэг нь солигдох тул бодлого нь харьцангуй тогтвортой дээд танхим байгуулжээ. АНУ-ын үндсэн хууль үндсэндээ социалист биш бүх үндсэн хуулийн үлгэр болсон гэдэг. Жишээ нь Японы үндсэн хуульд Локийн хүн бүр “амь нас, эрх чөлөө, хувийн өмч” –ийн эрхтэй гэсний сүүлчийнхийг (боолын эзэн байсан) Жефферсн “аз жаргалтай байх” гэж өөрчилснийг үгчлэн оруулж, хүний эрхийн нийтлэг зарчмуудыг хангах нь төрийн дээд зорилго ба өмчийн эрх халдашгүй (XIII) гэж тунхагласан байна. АНУ-ын бас нэг онцлог нь хуулийн өмнө төр үндсэндээ иргэд шиг эрхтэй субъект болдог ба төрийн шийдвэр хуульд нийцэж байгаа эсэхийг шүүх тогтоох (judicial review) эрхтэй байдаг тул үндсэн хуулийн цэц, захиргааны шүүх гэж байдаггүй.

АНГЛИД

Хууль бол ноёлогч ангийн хүсэл зоригийн илэрхийлэл гэж Марксизм сургадаг бол “Хүний үнэ цэнэд үндэслэсэн нийгмийн зохистой зүй тогтол болох natural law буюу төрөлхийн хууль байдаг, хуульчдын үүрэг нь түүнийг танин тунхаглаж, амьдралд хэрэгжүүлэхэд оршино” гэж эрх зүйн сонгодог философи үздэг. Шашин хүчтэй дундад зууны үед үүнийг бурхны сургаалиас гаралтай гэж байсан бол, их гэгээрлийн үеэс

нийгмийн харилцааны шинжлэх ухаанч үзэл, ардчиллын онолоор тайлбарлах болов. Аливаа шашны алтан дүрэм нь өөртөө ямар байлгамаар байгаагаар бусадтай харьц гэдэг бол Марксын коммунист тунхагтай зэрэгцэн “Улс төрийн эдийн засгийн ухааны зарчмууд” суут бүтээлээ туурвиж байсан Жон Стюарт Милз нийгэм хөгжихийн тулд хүмүүс бусдад хоргүй бүхнийг хийх эрхтэй байх ёстой, харин бусдын эрх ашгийг хохироох

ХУУЛИЙН ЗАСАГЛАЛ

аливаа үйлдлээс хууль төр хамгаалах ёстой гэж сургажээ. Амьдрал дээр хууль нь зөрчил маргааныг зөв шийдэх, нийгмийн шударга ёс тогтоохын төлөө олон мянганы чармайлтын үр дүнд гарч ирсэн (түүний дотор үндсэн хуулийн) нийтлэг зарчмууд юм. Анх Англи 1642-1645 оны иргэний дайнд парламентын тал хааныг ялснаар, хувь хүний эрх чөлөө, аюулгүй байдлыг хангахад төрийн үүрэг оршино гэж Жон Лок тунхагласан үндсэн хуульт бүгд найрамдах улс болжээ. Гэтэл үндсэн хууль гэдэг тодорхой нэг хууль одоо ч байдаггүй. Үндсэн хуулийн гол эх үүсвэрт 1679 оны “Habeas Corpus” буюу зөвхөн шүүхийн өмнө эрхээ хамгаалж, буруутайг нь нотолсон нөхцөлд хүнийг баривчилж болох тухай хууль, 1689 оны “Bill of Rights” буюу хүний үндсэн эрхүүд, түүний дотор хүний эрх чөлөөг хязгаарлах асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж, хэт их торгууль буюу хэрцгий ял оноохгүй байх тухай хуулиуд ордог. Ялсан намын удирдагч Ерөнхий сайд болж, парламентад сонгогдсон гишүүдээсээ кабинетаа бүрдүүлдэг парламентын засаглал мөн энэ үеэс

эхэлжээ. Хаан зөвхөн бэлгэдлийн үүрэгтэй болж, хаангүй орнууд нийгэмд нэр хүндтэй ахмад нэгнийг мөн бэлгэдлийн төрийн тэргүүнээр дэвшүүлэх болжээ. Гэхдээ энэ талын зохицуулалт тодорхой нэг хууль гэхээсээ, ихэнхдээ уламжлал, удаа дараагийн парламентын шийдвэрээр хийгдсэн байдаг. Жишээ нь сонгуульд оролцох эрхийг хөрөнгөтэй боловсролтойгоос нь эхлэн аажмаар өргөтгөж, нийтийн танхимын популизмыг хязгаарлах үүрэгтэй Лордууд буюу язгууртны танхим саяхныг хүртэл сонгуулиар биш үе дамжин ирсэн байдаг. Энэ бол улсаар тэжээлгэх хүсэлтэй, бололцоо боловсрол нимгэн давхаргын популист нөлөөг сааруулж, татвар төлж ирээдүйг бодож зарцуулах сөхөө буюу, Аристотелийн хэлснээр “арете” мэдлэг чадвартай Аристократуудаар төрийн санхүүг удирдуулах философи юм. Ийм учир Милз төрөөс тэтгэмж авдаг хүмүүсийн сонгуулийн эрхийг хязгаарлаж, дээд боловсролтой иргэдэд зургаан ажилчинтай адил санал олгохыг зөвлөж байв.

МОНГОЛД



Монголын хувьд ЗХУ-ын бүх хуулийг хуулж ирсний дээр (сургуульд бусад социалист орнуудын хууль утга адил ч томъёолол өөр, манайх үг үсэг зөрөхгүй байхаар ичдэг байв) гол нь мэдээлэл, мэдлэг оросоор авдгаас социалист хуулийн философи амь бөхтэй байна. 1992 оны үндсэн хууль парламентын засаглалыг сонгосон боловч бүх ард түмнээс сонгогддог, эзэн хаан/ их удирдагчийн уламжлал гэмээр бэлгэдлээс хол давсан олон эрхтэй Ерөнхийлөгч оруулсан нь засаглалын зааглалыг үймүүлж, ялангуяа гадаад бодлого, батлан хамгаалах, хуулийн засаглалын амин чухал асуудлуудаар ганц хүнээс шалтгаалсан популизм, гадны буюу бизнесийн сонирхол төрийн бодлогыг завхруулах боломж олгосон инстүүц бий болгожээ.

Үргэлжлэл бий

WORLDWINE
Vinotage



*River Tower -ын 2 давхарг
шинэ салбар нээгдлээ
Утас: 7777-4747*



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.02.10-ны дугаар
Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

ГАДААДАД БАЙГАА МОНГОЛЧУУД

Монгол 3.2 сая хүнтэй, түүний 4.5 хувь нь гадаадад амьдарч байна. 2017 онд Гадаад Харилцааны Яамнаас гадаадад сурч, ажиллаж буй иргэдийн тоог гаргасан. Дэлхийн 67 оронд 144,566 буюу Баянхонгор, Булган аймгуудын хүн амтай тэнцэх тооны монголчууд гадаадад амьдарч байна. Үүнээс 18 хүртэлх насны 23,990; 18-аас дээш насны суралцаж буй 25,986; албан ёсоор хөдөлмөр эрхэлж буй 26,697 хүн байгаа. 2018 онд Монгол улсын харьяатаас 490 хүн татгалзсан.

Монголд бараг өрх бүрээс хэн нэгэн нь гадаадад ажиллаж, ар гэрээ тэжээж байгаа. Дэлхийн Банкны тайлангаар гадаадаас Монгол руу 2010 онд 266 сая доллар шилжүүлж байсан бол 2018 онд 332 сая доллар болсон нь ДНБ-ий 2.7 хувьтай тэнцсэн.

Яагаад хүмүүс ингээд гадаад орнууд руу яваад байгаа юм бэ?

Хамгийн гол шалтгаан нь Монгол улсын эдийн засагтай холбоотой. Иргэд амьдралаа авч явах хэмжээний орлоготой ажил олох боломжгүй, хувийн бизнесээ эрхлэх орчин нөхцөл байхгүй байна. Төр засаг дахь авлигаас болоод шударгаар өрсөлдөх боломжгүй, зээлийн хүү өндөр, татварын дарамт ч их. Монголбанкны мэдээлснээр 2018 онд хувь хүнд олгох банкны зээлийн дундаж хүү жилийн 18, аж ахуйн нэгжид бол 15.5 хувь байна. Бизнес эхлэхэд шууд л татвар авдаг, бусад орон шиг татварын чөлөө олгодоггүй. ЖДҮ-ийг дэмжих төсвийн хөрөнгийг нь хууль тогтоогчид өөрсдөө авчихдаг. Бас салбарынхаа сайдын компанитай хэн өрсөлдөж чадах билээ дээ.

Дараагийн том шалтгаан бол нийгмийн асуудал. Иргэд ажилгүй учир ядуу, ядуу учир бухимдалтай байна. Нийслэлийн нийтийн эзэмшлийн газруудыг хотын дарга нар нь хуваагаад авчихсан учир замын түгжрэл нь нийгмийн хөгжлийг гацаах боллоо. Хүн амын хагас нь буй нийслэл хотын агаарын бохирдол нь өдрийн цагаар урд талын машин харагдахгүй

түвшинд очжээ. Олон мянган хүүхэд утаанд хордон нас барж байна. Энэхүү түгжрэл, хорт утаа, нийгмийн шударга бус явдал газар авч иргэдийн бухимдал тэнгэрт хүрч, ирээдүйдээ итгэх нь навс унаж байна. Нийгмийн шударга бус байдал ямар ч үнээр хамаагүй хурдан баяжих хүслийг өдөөж байна. Ихэнх иргэд гадагшаа явахыг хичээх болов. Өмнөд Солонгост одоо 46 мянган монгол хүн амьдарч буйгаас тал нь хууль бусаар, тэдний хагас нь ажил хайж байна.

Гурав дахь бүлэг шалтгаан бол гадаадын өндөр хөгжилтэй оронд сурч боловсрох, эсвэл эрүүл мэндийн үйлчилгээ авах, аялаж жуулчлах урсгал юм. Мөн гадаадын иргэдтэй гэр бүл болж байгаа хүмүүсийн тоо нэмэгдсээр байгаа.

Үүнийг зогсоох арга байна уу? Аль эсвэл зүгээр зөнд нь орхих уу?

Эдийн засаг, улс төр, хувь хүний хүсэл зэрэг олон шалтгаантай, дэлхий нийтийн түгээмэл болсон энэ үзэгдлийг ардчилсан улс оронд хэн ч хүчээр зогсоож чадахгүй, боломжгүй. Энэ нүүдлийг ухаалгаар удирдах сорилт Монгол улсад тулгараад байгаа.

Энэ ажлыг юуны өмнө гуравдагч хөршийн бодлогоор зохицуулж, тэдгээр орны иргэд болсон монголчуудад давхар иргэншилтэй байхыг зөвшөөрөхөөс эхлэж болох юм.

Гадаадаас иргэдээ буцаж ирүүлэх оролдлого хийж байсны жишээ бол 2011 онд Сү.Батболдын Засгийн газраас хэрэгжүүлсэн Зөгийн үүр, 2016 онд Ч.Сайханбилэгийн Засгийн газрын баталсан Дэлхийн Монголчууд хөтөлбөрүүд юм. Төр засгийн цөөн хэдэн албан тушаалаас өөр ажил олгож чадаагүй, хувийн бизнес хийхэд нь чиглэл, боломж өгөөгүй, татварын бодлогоор дэмжээгүй учир олон тоогоор хүмүүс ирээгүй, эдүгээ зарим нь буцаад гадагшаа явчихсан.

Одоогийн нөхцөлд бид том том бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэхээс илүүтэйгээр бага, багаар итгэл олох үйл ажиллагаа явуулах нь зохистой. Тухайлбал төр засгаас бодлогоор

ажиллах хүч явуулж байгаа бол, буцаад ирэхэд нь ямар ажлын байр бэлэн байхыг бодолцох хэрэгтэй. Япон руу олноороо явсан залуучуудад тухайн мэргэжлийн Японы сертификат авах боломж олгох, буцаад ирэхэд нь Монголд сурсан чиглэлээрээ ажиллах боломж олгоход анхаарна гэсэн үг.

Дараагийн чухал алхам бол соёлын буюу зөөлөн хүчний бодлого. Монгол хүн гэдэг нь юуны түрүүнд Монгол хэлээ эзэмшихийг хэлнэ. Гадаадад байгаа хүүхдийг хэлээ сурахад нь бүх талаар туслаж дэмжих шаардлагатай байна. Эх эцэг нь гэртээ ядаж монголоор ярьж хэвших,

унших, сонсох үлгэрийн номоор бүрэн хангах, ашиглахыг нь урамшуулах хэрэгтэй байна. Хүүхдүүд хоёр унаган хэлтэй байж өрсөлдөх чадвартай болно гэдгийг үргэлж санах хэрэгтэй. Монголчууд олноороо амьдарч буй улсуудад суугаа элчин сайдын яамдууд, консулын газрууд энэ талаар онцгой анхаарч, идэвх санаачилгатай ажиллах цаг болжээ.

Нөгөө талаасаа гадаадад амжилттай ажиллаж буй хүмүүсийн жишээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр маш их гаргадаг шигээ, Монголдоо ирээд амжилттай ажиллаж буй жишээг түлхүү харуулах хэрэгтэй байна.

ЭРХ ЧӨЛӨӨ БА МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

Үйл явдлын товч:

Туркийн “Мармара” нийгэм, стратегийн судалгааны сангаас жил бүр “Евразийн эдийн засгийн чуулган”-ыг зохион байгуулдаг. Евразийн бүс нутгийн орнуудын төрийн тэргүүн, хувийн хэвшил зэрэг томоохон байгууллагуудын төлөөлөгчид уг чуулганд оролцдог.

Уг чуулганы 22 дахь удаагийн уулзалт өнгөрсөн өдрүүдэд Туркийн Станбул хотод болсон. Глобалчлал цаашид яах вэ? Популизм цаашид ямар үр дагавар авчрах вэ зэрэг дэлхий нийтэд тулгарч буй томоохон сэдвүүдийг хөндсөн. Евразийн бүс нутгийн орнуудын дийлэнх нь хөгжиж буй орнууд байдаг. Тэр дундаа 1990 оноос өмнө социалист дэглэмтэй байсан улс орнууд олон бий.

Дүгнэлт тайлбар:

Евразийн эдийн засгийн чуулга уулзалтад та оролцож илтгэл танилцуулсан. Илтгэлийн гол санаагаа хуваалцаач. Уулзалтын ач холбогдол юу байв?

Би энэ жил анх удаа уригдсан. Өмнө нь манай төр засгийн бараг бүх Ерөнхийлөгч, сайд дарга нар оролцож байсан юм билээ. Энэ удаа иргэний нийгмээс гээд намайг урьсан. Чуулганд 17,18 орны одоо байгаа болон байсан Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд хүмүүс ихэнх нь байна лээ. Улс төр, эдийн засгийн нөхцөл байдал ямар байгаа, яах талаар санал бодлоо хэлсэн ерөнхийдөө тун дипломат яриатай үйл ажиллагаа болсон.

Countries	Population Mln	Freedom (political rights and civil liberties)*	Press freedom*	Press freedom index 2018 **	by RWB** Ranking 180 countries
Mongolia	3.2	Free 1/7	Partly free	29	71
China	1,400	Not free 6.5/7	Not free	78	176
Russia	144	Not free 6.5/7	Not free	50	148
Kazakhstan	18	Not free 6/7	Not free	54	158
Kyrgyzstan	6.1	Not free 5/7	Not free	31	98
Uzbekistan	32	Not free 7/7	Not free	61	165
Azerbaijan	10	Not free 6.5/7	Not free	60	163
Armenia	3	Partly free 4.5/7	Partly free	29	80
Turkey	80	Not free 5.5/7	Not free	53	157
	1,700	Only 3 M in MNG, 3M in Armenia.		Pro, bad, vbad	

Нэгдүгээрт би хэвлэл мэдээллийн салбарын хүн, хоёрдугаарт хүний эрх, үгээ хэлэх эрх чөлөөний тухай тэнд ярих шаардлагатай байсан. Тиймээс би илтгэлдээ “Би өчигдөр Монголоос Турк хүртэл нисэж ирлээ. Замдаа 9 орны нутаг дэвсгэр дээгүүр нисдэг юм байна. Тэгээд эдгээр орны хүмүүс ямар хэмжээний эрх чөлөөтэй, амар амгалан амьдарч байгаа юм бэ?” гэдгийг хэлсэн. Ингээд үзэхэд Монгол, Хятад, Орос, Казахстан, Киргизстан, Узбекистан, Азербайжан, Армения, Турк гэсэн энэ 9 улсыг жагсаагаад үзэхэд нийлбэрээр 1,7 тэрбум хүн амьдарч байгаа ба эдгээр улсуудаас үг хэлэх бүрэн эрх чөлөөтэй ганц орон бол 3 сая хүн амьдардаг Монгол улс байгаа юм. Үг хэлэх хагас эрх чөлөөтэй нь Армения улс тэнд мөн 3 сая хүн амьдардаг. Ингэхээр 1,7 тэрбум хүнээс зөвхөн 6

сая нь үгээ хэлэх эрх чөлөөтэй амьдарч байгаа юм. Үг хэлэх эрх чөлөөг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбож ярьсан.

Бүс нутгийн орнуудтай харьцуулахад Монгол улс өнөөдөр хэвлэлийн эрх чөлөөгөөрөө ямар түвшинд байна вэ? Анхаарах зүйл юу байна?

Илтгэлдээ Монгол улсад асуудал байгаа гэхдээ үүнийгээ ярих, хэлэлцэх эрх чөлөө байгаа гэж хэлсэн. Харин зарим улсууд болохгүй юм байгаа хэдий ч түүнийгээ ярихгүй, ярихыг нь зөвшөөрөхгүй байгаа юм. Ер нь бол үгээрээ ярихгүй газар сумаар ярьдаг шүү дээ гэж хэлсэн. Тийм ч учраас ярилцахгүй байгаа газар ардчилал, хүний эрх байхгүй гэсэн үг шүү дээ.

ТӨР БА НАМД ИТГЭХ ИТГЭЛ АЛДАРСАН НЬ

Хуулийн дагуу улс төрийн намыг Улсын дээд шүүхэд бүртгэдэг. 2018 оны 2-р сарын байдлаар Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 31 улс төрийн нам байна.

2018 онд “Улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс” гаргах үед 28 нам байсан. Дараах намууд сүүлд нэмэгдсэн байна.

Ард түмний олонхын засаглал нам (АТОЗН)

Их эв нам (ИЭН)

Гэр хороолол хөгжлийн нам (ГХХН)

Улс төрийн намуудад иргэд яагаад итгэхгүй байна вэ? Хоёр том нам ч адилхан, гуравдагч хүчнүүдэд ч итгэхгүй байна.

Монгол улсад парламентын хямрал нүүрлээд байна. Энэ хямралын эх сурвалж нь улс төрийн намуудын хямрал юм. Улс төрийн намын хямрал бол төрийн, цаашлаад эдийн засгийн, араас нь нийгмийн хямрал болгодог домино нөлөөтэй гэдгийг монголчууд улам хүчтэй мэдэрч байна.

Ер нь нам гэж чухам юу юм бэ? Нам гэдэг бол улс төрийн эрх мэдэл олж авахын төлөө өөрсдийн үнэт зүйл, бодлогоор нэгдсэн бүлэг хүмүүс. Улс төрийн намын гол үүрэг бол иргэд, төрийг холбосон гүүр байх явдал. Монголын улс төрийн хоёр том нам тодорхой цаг хугацааны хүрээнд тийм гүүр мөн гэж иргэд болон намын гишүүд нь үздэг байсан ч, итгэл үнэмшил нь улам бүр буурч байна. Ер нь иргэд улс төрийн намуудаас хөндийрөх, намуудад дургүйцэх хандлагатай

болсоор байна. Үүнд хэд хэдэн шалтгаан бий.

НЭГ, Монголд улс төрийн намуудыг янз бүрийн нэрээр төсвөөс санхүүжүүлэх нь улам их болсоор ирлээ. Улс төрийн намыг төсвөөс санхүүжүүлэх нь нэг талаас улс төрийн авлигыг бууруулах сайн талтай ч, нөгөө талаас намыг иргэний нийгмийн байгууллага биш болгоход түлхэц өгч байна. Өөрөөр хэлбэл гишүүдийн хураамж, иргэдийн хандиваас хамааралгүй болгож байна.

ХОЁР, Намуудын бодит гишүүнчлэл буурч байна. Өмнө нь маш олон гишүүнтэй байсан учраас нам төлөөллийн байгууллага болж чадаж байсан. Одоо манай хоёр том нам тус бүр 150 гаруй мянган гишүүнтэй гэх боловч намын удирдлагын сунгаа явуулахад бодит гишүүдийнх нь тоо арав дахин бага болж байлаа.

ГУРАВ, Намууд орчин цагтаа таарахгүй, гологдож байна. Бүтэц зохион байгуулалт, бодлого, үзэл санаа гээд бүх түвшиндээ хоцрогджээ. Ялангуяа бүтэц зохион байгуулалтын хувьд социалист нийгмийн нэг намтай, тэр нь төрийг орлодог, данхар бүтэц, захиргаадалтын сэтгэлгээнээс салж чадахгүй байна.

Дефакто Институтээс 2018 онд хийсэн “Улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс” судалгааны үр дүнд манай улс төрийн намууд хагас инстүүчлэгдсэн гэж гарсан. Ардчилсан нам жишээлбэл үүр болгон нь тусдаа байгуулал шиг үйл ажиллагаа явуулж байна. Тэд харилцан мэдээллээ солилцдоггүй, бүр нууцалдаг. Улс төрийн намууд санхүүгийн тайлангаа ч

гаргадаггүй, хуулийн дагуу зарим мэдээллээ вебсайт дээрээ цөөн хоног байрлуулаад буцаагаад авчихдаг. Тэгээд ч монгол улс төрийн намууд тайлангаа гаргах ямар нэг стандарт, загвар байхгүй.

Улс төрийн намын хямралаас гарахын тулд яах ёстой вэ?

НЭГ, Монгол улс төрийн намын системээ инстүүчлэхийн тулд улс төрийн тогтолцоогоо дахин харах шаардлагатай боллоо. Хагас Ерөнхийлөгчийн тогтолцоо нь улс төрийн намын инстүүчлэлд сөргөөр нөлөөлдөг болохыг дээр дурдсан Фернандо Касал Бертаогийн судалгаа харуулжээ. Манай үе үеийн Ерөнхийлөгчид фракцын улс төрийг бий болгодог, дэвэргэдэг гол хүчин зүйл нь болдог. Фракцууд намуудыг системийнх нь хувьд нураах алхмуудыг тогтмол хийж ирлээ. Монгол бол уг нь парламентын засаглалтай, Ерөнхийлөгч бол бэлэг тэмдгийн албан тушаал.

ХОЁР, Намуудын дотоод ардчиллыг хөгжүүлэх шаардлагатай байна. Сүүлийн хэдэн жилд УИХ-ын чуулган эхлэх болгонд хэлэлцэх асуудлуудын жагсаалтад ордог ч, хэзээ ч хэлэлцдэггүй нэг хууль бол Улс төрийн намын тухай хууль. Шалтгаан нь их энгийн. Энэ хуулийг хэлэлцэж чадахгүй хэмжээнд ортлоо улс төрийн намууд маань олигархи бүлэглэлийнхээ барьцаанд орчихоод байна. Уг нь энэ хуулийг яаралтай батлах, батлахдаа улс төрийн намыг иргэдтэй илүү ойртож ажиллах, зохион байгуулалтын

хувьд уян хатан, цомхон бүтэц рүү шилжүүлэх хэрэгтэй юм. Ингэхдээ гишүүдийн оролцоо, өрсөлдөөн, ил тод байх, тайлагнах зэрэг намын дотоод ардчиллын гол функцуудыг тодорхой тусгах хэрэгтэй. Манайд 20 жилийн турш дарга нь ганц ч солигдоогүй нам хүртэл бий.

ГУРАВ, Иргэний нийгмийг бүрдүүлж, төлөвшүүлэх хэрэгтэй байна. Чехийн судлаач Михайл Клима “Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал” номондоо пост коммунист орнуудад улс төрийн намууд дээрээсээ, бас доороосоо иргэдэд биш санхүүжүүлэгч эзэддээ эзлэгдэж, улс төрийн клиентелист тогтолцоо бий болсныг тод бичжээ. Үндсэн шалтгаан нь иргэний нийгэм бүрдээгүй, төлөвшөөгүйтэй холбоотой гэж тэр дүгнэсэн. Намууд нь улс төрийн тогтолцооны дэд системийн хувьд иргэний нийгэм, чөлөөт хэвлэл зэрэг бусад системүүдтэйгээ харилцан уялдаатай учир, өөрөө дангаараа шинэчлэгдэх боломжгүй.

У.Черчилль “ардчилал бол хамгийн муу систем гэхдээ үүнээс дээрийг хүн төрөлхтөн хараахан олоогүй байна” гэж хэлсэн шиг улс төрийн намууд муу, гэхдээ улс төрийн намгүй ардчилал гэж байдаггүй. Тиймээс улс төрийн намын тогтолцоогоо яаж инстүүчлэх вэ, яаж тогтвортой, цомхон систем болгох вэ гэдэг л монголчууд бидний өмнө тулгараад буй түүхэн сорилт болж байна.

Улс төрийн намыг төлөвшүүлэхгүйгээр Монгол улс өөрөө төлөвшөхгүй юм байна лээ.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх
боломжтой.*

GOOGLE STORE

APP STORE



Та “Дефакто Газет” цахим сонинг төлбөргүй, тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ үү.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан
Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn
www.jargaldefacto.com